

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Бунибазарын Доржийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Бунибазарын Дорж хуучин Халх монголын Түшээт хан аймгийн Говь түшээ гүний Түшээт ван Чагдаржавын хошууны 25 дугаар багийн харьяат, одоогийн Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг “Жаргалант” гэдэг газар европын он тооллоор 1878 оны 01 дүгээр сард, хуучин билгийн тооллоор XV жарны шар барс жилийн, хаврын тэргүүн бар сарын, бар өдрийн, бар цагийн, бар мөчид, өөрөөр хэлбэл 5 бар мөч тохиосон өдөр Боржигон овогтой Хохь тайж (албат хамжлагагүй) Бунибазарын 5 дугаар хүү болон мэндэлжээ.

Б.Дорж багаасаа эцэг, эхийн асрамжид өсөж хүмүүжин нүүдэлчин ухаан, эх оронч үзэл шингэсэн сэхээтэн болон төлөвшсөн байна. Өөрийн чармайлт болоод гэрийн зэгсэн боловсролтой болсон залуу Доржийн ур чадварыг төр засгаас анхааран үзэж, Богд хаант засгийн үед алба хашиж байх үед эзэн хааны зарлигаар 22 настайдаа их бага туслагч, захирагч мэйрэн тушаалд дэвшин ажиллаж, **“Мэйрэн”** цолыг хүртсэнээр ард олондоо “Мэйрэн Дорж” хэмээн алдаршсан билээ. Төрт ёсны их түүхэн уламжлалт бичиг цэргийн эрдэмд нэвтэрхий Б.Доржийг 1921 оны намар Ардын засгийн газраас Нийслэл хүрээнд дуудан ирүүлж, Богд хаант Монгол Улсын Гадаад явдлын яамны бичгийн албан хааж байсан байдлыг харгалзан Ардын засгийн Гадаад явдлын яаманд түшмэлээс эрхэлсэн түшмэл хэмээх өндөр хариуцлагатай албанд томилон ажиллуулж байсан шалгарсан боловсон хүчин байжээ. Улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөөг сэргээн мандуулах үйлсэд хүчин зүтгэгч бөгөөд “Мэйрэн” тушаалтан ёсоор Монгол нутгийн Өмнөд зүг рүү довтолж, ард иргэдийг цөлмөн дээрэмдэх оролдлого хийж байсан Хятадын гамин цэргүүдийг замаас нь отож, тэмцэн хөөх ажлыг зохион байгуулж, тэднийг устган нутаг орныхоо ард иргэдийг аварч, амгалан тайван болгож байсан юм. Тэрээр нутгийн иргэдээс 100-аас доошгүй эрчүүдийг цэрэгт татан гаминтай байлдан тэднийг устгаж, хөөж явуулан ард түмнээс дээрэмдсэн эд хөрөнгийг нь эздэд нь эргүүлэн өгөх, улсын санд шилжүүлэх арга хэмжээг авч ирсэн цэргийн зүтгэлтэн, манай улсын анхны партизануудын нэг байсан нь батлагдах боловч улсын “Партизаны комисс”-оос Б.Доржид **“Партизан”** гэдэг цолыг нэхэн олгоогүй байна.

1921 оны 12 дугаар сард Монголын үндэсний худалдааны эх үүсвэр болох харилцан туслалцах хоршоог анх байгуулахад Б.Дорж нь 115 лан мөнгөөр хувь нийлүүлж, Нийслэл хүрээний анхны хоршооны гишүүнээр элсэж, хоршооны гишүүдийн бүртгэлийн 55 дугаар бичигдэж, “Боловсон худалдаа” сонингийн анхны эрхлэгч бөгөөд уг сонинг эрхлэн гаргагсдын нэг байжээ. Монголын худалдааны байгууллагын анхны хоршоог үүсгэн байгуулах их ажилд Б.Дорж идэвх зүтгэлтэй оролцож, ард олныг худалдаагаар хангахад өөрийн бие зүтгэлээр тэмцэж, 1925 онд Хятадын Буут хотод 1 сар орчим, Яргай хотод 1927-1929 оныг дуустал худалдаа хийж байсан талаар Улсын Дотоод явдлын яамны 1958 оны 81 тоот албан бичигт дурдсан байна.

Ардын засгийн эхний жилүүдэд Засгийн газрын туслах түшмэлийн албыг хашиж байгаад 1923 онд Сангийн явдлын яамны сайдаар томилогдсон байна. Сангийн сайд

Б.Дорж (1923.04.06- 1924.11.29-ний өдөр хүртэл) ажиллах хугацаандаа улсын санхүү, орлого, зарлага, худалдаа, татварын бодлогыг сайжруулж, улсын сан хөмрөгийг арвижуулах, орлогыг нэмэгдүүлэх зорилго тавьж, эдийн засаг, санхүүгийн жилийн төсөв зохиох, биелэлтийг дүгнэх, улсын орлого, зарлагыг нарийн, тодорхой данс, бүртгэлтэй болгохын тулд Сангийн явдлын яамны Нягтлан бодох бүртгэлийн хэлтэст бичиг үсэг, сампин бодлогын мэдлэг сайтай залуучуудыг ажиллуулж, энэ чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх санаачлагы гаргасан байна. Мөн цаасан мөнгөн тэмдэгтийг бий болгох банкны дүрмийг боловсруулан 1924 оны 6 дугаар сард Засгийн газраар батлуулан хэрэгжүүлснээр Улсын санхүүгийн системийг бүрдүүлж, гадаадынхны тонон дээрэмдлэгийг таслан зогсоожээ. Түүнчлэн, ЗХУ-ын тусламжтайгаар Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа, үйлдвэрийн банк байгуулж, улс төр, аж ахуйн ач холбогдолтой санхүүгийн системийг бий болгожээ. Хятадын худалдаачдын Монголд өгөх, авах барааны жин, бан, лан, пүү гэсэн жин хэмжүүрүүдийг ард түмэнд ашигтай болгон, Хятадын худалдаачдын мөнгө хүүлэх аргыг өөрчлөн, энэ талаар 1924 онд Засгийн газарт санал оруулж, Жин хэмжүүрийн тасгийг Сангийн явдлын яамны харьяанд байгуулан, мод, төмрийн сайн дархчууд, Дархан вангийн харьяаны нэртэй сайн дархан Пунцагцэрэн, мөн Түшээт вангийн хорооны дархан Сайн-Өлзий нарын 5-6 хүнийг орон тоогоор авч ажиллуулан, гүйлгээнд хэрэглэгдэж байсан хятадын жин, алт, мөнгөний дэнсийг дундаж сайн хэмжүүртэй харьцуулан шалгаж, зөрүүтэйг тохируулах, мөн шинээр хийсэн дээрх нарийн хэмжүүрүүдийг шалган тохируулга хийж, Сангийн явдлын яамаар «Сан» гэсэн үсэг бүхий тусгай дугаарыг хэмжүүр дээр цохиж батлан, гүйлгээнд хэрэглэх зөвшөөрөл олгож байв.

Нутаг орныхоо хөгжилд хэзээд анхаарал тавин, хөгжүүлэхийн төлөө зүтгэж ирсэн Б.Дорж нь Өмнөговь аймгийнхаа анхны тулгийн чулууг босгож, 1930 онд нутгийн захиргааны өөрчлөлтөөр Дэлгэрхангай уулын хошууг Дундговь, Өмнөговь гэдэг хоёр аймагт хувааж, Өмнөговь аймгийг шинээр байгуулахад аймгийн төвийг хаана, ямар газар байрлуулбал алсдаа хот болон өргөжиж хөгжихөд тохиромжтой сайн газрыг сонгон олох асуудалд Б.Доржийг алс холын бодолтой, говь нутагт өсөж төрсөн хашир туршлагатай хүн хэмээн түүнд хариуцуулж байжээ. Ингээд аймгийн төвийг анх Хармагтай, Даланзадгад хоёрын аль нэгэнд байрлуулахаар хэлэлцэж, эцэст нь Б.Доржийн санал дэвшүүлэн сонгосноор Даланзадгайтын булагыг түшиглэн байрлуулан төвлөрүүлжээ.

Б.Доржийн мал аж ахуйн өргөн мэдлэг болоод бичиг эрдмийн их чадварыг үндэслэн “Тайлбар толь” зохиох тухай БНМАУ-ын Ерөнхий сайдын 1933 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Товчооны гишүүдийн 01 дүгээр тогтоолоор тайлбар толийн комиссыг Б.Ринчен, С.Шагж, М.Гомбожав, Б.Дорж, Я.Цэвэл, Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж нарын бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсан. Б.Дорж бол манж, төвд, хятад, орос хэлийг эзэмшсэн, уйгаржин Монгол үсэг, бичгийн дүрэм сайн мэддэг, мөн үгийн сангийн баялаг ихтэй, ардын домог, ярианы их мэдлэгтэй хүн байсан учраас Шинжлэх ухааны хүрээлэнд ажиллаж байхдаа “Монгол хэлний тайлбар толь” бичих ажилд идэвхтэй оролцон ажиллажээ.

Тэрээр нийслэл хүрээний сонинд нууц бүлгийн гишүүдтэй хамтран сэтгүүлчээр ажиллаж, үндэсний эрх чөлөөний өрнөлт зорилго, чиглэл, Монголын гадаад, дотоод байдал, төр, эдийн засгийг хамгаалан, хар, шар феодалын эсрэг тэмцэх, Манж Чин улсын мөлжлөгөөс ангижирч, тусгаар тогтнолоо бэхжүүлэх, ард түмний амьдралыг сайжруулах зэрэг олон талт асуудлуудыг тусгасан дэвшилтэт үзлийг сурвалжлан

бичдэг байжээ. XX зууны эхэн үед Монгол орны нийгэм, эдийн засаг, феодалын гаж бурангуй ёс, шарын шашны мунхруулагч үзлийг шүүмжлэн, ард түмэнд шинэ соргог үйл хэргийг сурталчилж байв. “Туулай, төлөг, чоно гурвын үлгэр”, “Заяатын шунал”, “Чоно бухын арганд унасан нь”, гэх мэт олон ном, шүлэг үлгэр, өгүүллэг зохиож бүтээсэн бөгөөд зарим бүтээл нь Ц.Дамдинсүрэнгийн “Зуун билиг”, “Монголын уран зохиолын эмхэтгэл”-д, мөн сонин, хэвлэлд, тухайлбал 1913 онд анх нээсэн “Шинэ толь” сонины нэгэн дугаарт гарсан байдаг.

Б.Дорж нь улс орныхоо төлөө өндөр мэдлэгтэй болж, их үйл хэргийг бүтээсэн олон талын авьяас чадвартай, шулуун шудрага, хүнлэг чанартай байсан зэрэг нь туулж өнгөрүүлсэн замналаас нь тодорхой бөгөөд энэ хүний талаар бичсэн ном, хэвлэл, нийтлэл олон бий. Тухайлбал, түүний анхны шавь, БНМАУ-ын Гавьяат багш Ч.Түмэн нь Дорж мэйрэн багшийнхаа тухай 1980 онд “Их говийн хичээнгүй Дорж мэйрэн”, 1988 онд “Харанхуй манангаас гэгээн гэрэлд” гэдэг хоёр ном бичиж хэвлүүлсэн. Ж.Батхүүгийн бичсэн “Ээдрээ” хоёр боть роман, Өмнөговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулж Баян-Овоо сумын уугуул С.Батсүхийн 2013 онд бичсэн “Их говийн сургамжит хичээнгүй Дорж мэйрэн”, Дорж мэйрэнгийн зээ дүү Ц.Батмөнхийн бичсэн “Говь түшээ гүний Дорж мэйрэнгийн намтар”, Ц.Батмөнхийн охин Б.Ербишийн 2018 онд бичсэн “Миний өвөг дээдэс, удмынхан” ургийн ном, хүү Б.Энэбишийн 1990 онд “Говийн мэдээ” сонинд бичсэн нийтлэл, 2008 онд бичсэн “Б.Дорж мэйрэнгийн тухай” намтар, Мажаагийн бичсэн “Өмнөговийн Бага нэвтэрхий толь”, их эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн 1990 онд бичсэн “Намтрын хуудсууд” ном зэрэг материал, баримт бичиг байна. Түүнчлэн, ЗХУ-д хэвлэгдсэн “Азийн сэргэн мандалт” гэдэг номонд Дорж мэйрэнг Ази, Монголын томоохон сэхээтний нэг гэж дурьджээ.

Монголын өмнийн говиос төрж, эх орныхоо тусгаар тогтнол, хөгжлийн төлөө 19-20 дугаар зуунд тууштай тэмцэж, гурван төрийн нүүр үзсэн, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, Гадаад явдлын яамны эрхэлсэн түшмэл, дипломатч, Сангийн сайд зэрэг өндөр алба хашиж байсан, олон талын авьяас билэгтэй “Дорж мэйрэн” хэмээн алдаршсан тунгаамал сэхээтэн Б.Доржийн түүхэн алдар гавьяаг үнэлж, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 163 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын дунд сургуулийг түүний нэрэмжит болгосон. Мөн Өмнөговь аймгийн Даланзадгад сум (хот)-ын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 31 дүгээр тогтоолоор Даланзадгад сум (хот)-ын Худалдааны төвөөс Нүнжиг худалдааны төв хүртэлх авто зам бүхий хэсгийг “Дорж мэйрэнгийн гудамж” гэж нэрлэж, мөн 2022 онд Даланзадгад сумын төвд Б.Доржид зориулсан хөшөө бүтээжээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын сайд, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Бунибазарын Доржийн мэндэлсний 150 жилийн ой 2025 оны 5 сард тохиож байгаатай холбогдуулан “Бунибазарын Доржийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын сайд, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн “Бунибазарын Доржийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/ дэх заалтад “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно” гэж заажээ.

Б.Доржийн Монгол улсад олон улсын харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалж, улсын санхүү, орлого, зарлага, худалдаа, татварын бодлогыг сайжруулж, улсын сан хөмрөгийг арвижуулах, орлогыг нэмэгдүүлж, улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөөг сэргээн мандуулах үйлсэд оруулсан үнэтэй хувь нэмэр, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах нь ирээдүй хойч үе түүхээ мэдэх, улс орноо хайрлан хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Тогтоолын төсөл нь 2 зүйл, 3 заалттай бөгөөд Бунибазарын Доржийн мэндэлсний 150 жилийн ойг 2025 оны 5 сард тэмдэглэн өнгөрүүлэх, дурсгалыг мөнхжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тусгана.

Богд хаант засгийн монгол цэргийн “Мэйрэн” цолтой захирагч, Гадаад явдлын яамны эрхэлсэн түшмэл, Монгол Улсын Сангийн сайд, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч, улсын сурын анхны мэргэн, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Бунибазарын Доржийн Монгол улсад олон улсын харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалж, улсын санхүү, орлого, зарлага, худалдаа, татварын бодлогыг сайжруулж, улсын сан хөмрөгийг арвижуулах, орлогыг нэмэгдүүлж, улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөөг сэргээн мандуулах үйлсэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах боломж бүрдэнэ.

Бунибазарын Доржийн амьдрал, ажил, бүтээсэн түүхийн талаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж, ирээдүй хойч үедээ түүхээ мэдэх, улс орныхоо тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгоход чухал нөлөөтэй.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулан хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах болон дагалдаж хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---oOo---